



“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ТЭЭВРИЙН ХЭЛТЭС-Т

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮТНЭЛТ

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

II хороо, Чингисийн өргөн чөлөө 11

Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15

И-мэйл: info@mrtд.gov.mn, <https://www.mrtд.gov.mn>

2016.11.10 № 8-07-003/10

**Стандартын шаардлага
хангасан эсэх тухай**

Танай хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2016 оны 11 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд Дорнод аймгийн Хэрлэн сум – БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Манжуур хот – Дорнод аймгийн Хэрлэн сум чиглэлд улс хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан “Монгол аялал” ХХК-ийн танилцуулга болон холбогдох материалыг үндэслэн тухайн компанийн боловсон хүчин, материаллаг бааз, тээврийн хэрэгслүүд стандартын шаардлага хангасан эсэхийг шалгалаа.

Товч мэдээлэл:

Тус компани нь 1999 онд “ЛИПН” ХХК нэртэйгээр байгуулагдаж, 2010 онд нэр өөрчлөгдөж, “Монгол аялал” ХХК нэртэйгээр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. Регистр 5421217, Улсын бүртгэлийн дугаар 9011256134.

2002 оноос аялал жуучлалын чиглэлээр зөвхөн гадаадын жуулчдад, 2003 оноос эхлэн “Монгол аялал” хөтөлбөрийг зохион байгуулж, дотоод аялал, жуучлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд компанийн зэргийг 2011 оны ЗТБХБСайдын 153 дугаар зөвлөмжийн дагуу хөдлөх бүрэлдэхүүний шилжүүлэх коэффициентыг ашиглан тогтооход 5 дугаар зэргийн авто аж ахуй нэгжид хамрагдаж байна.

Боловсон хүчний хувьд:

1. Захирал Ц.Пүрэвдорж – Уул уурхайн эдийн засагч мэргэжилтэй;
2. Нягтлан бодогч Ц.Пүрэвдорж – Эдийн засагч мэргэжилтэй;
3. Ерөнхий инженер Д.Нармандах – Автомашин, авто аж ахуй мэргэжилтэй, Механик-инженерийн бакалавр/диплом дугаар D200317768/-ын зэрэгтэй. Автотээврийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд төсөл, хөтөлбөрт үнэлгээ өгөх, зөвлөмж боловсруулах чиглэлээр мэргэшсэн инженер. Батламж гэрчилгээ № 14/876;
4. Засварын инженер Ж.Даваадаш – Батлан хамгаалахын их сургуулийг Авто машины ашиглалт мэргэжлээр төгссөн, техникийн шинжлэх ухааны бакалавр зэрэгтэй. Дипломын № D200721662; Автотээврийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд төсөл, хөтөлбөрт үнэлгээ өгөх, зөвлөмж боловсруулах чиглэлээр “мэргэшсэн инженер”-ийн зэрэг авсан боловч гэрчилгээний хугацаа дууссан. Батламж гэрчилгээ № 10/556;
5. Ашиглалтын инженер Г.Ууганбаатар – Батлан хамгаалахын их сургуулийг “Автомашин ашиглалт, авто аж ахуй” мэргэжлээр төгссөн, “Механик инженер” бакалавр зэрэгтэй. Дипломын № D 201238080;

6. Засварчин Л.Ганбат – ЗХУ-ын Краснодарск хотын Техник мэргэжлийн дунд сургуулийг автомашины засварчин мэргэжлээр дүүргэсэн. №12436;

7. Улс хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллах жолооч/8/ нь тохирох ангиллын үнэмлэхтэй, “D” ангиллын тээвэрлэгч жолоочоор мэргэшсэн байна.

Санхүүгийн хувьд:

Тус компани 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан/2016 оны 9 дүгээр сарын 30/-гаар өр төлбөрийн нийт дүн 65'041'772'83 төг, эздийн өмчийн дүн 84'044'071'71 төг, нийт хөрөнгийн дүн 195'085'844'54 төг байна.

Материаллаг бааз:

Тус компани нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 6.2-т заасны дагуу өөрийн өмчийн үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламж/засварын байр, дулаан болон ил зогсоол/-гүй байгаа боловч УБ хотод засвар үйлчилгээг хийлгэх болон дулаан гарааш түрээслэх гэрээг хот дотор нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч “НБЧ” ХХК-тай, Дорнод аймагт хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч “АйС ВН” ХХК-тай “Авто гарашид автомашин байрлуулах” гэрээ байгуулсан байна.

Тээврийн хэрэгслийн хувьд:

Тээврийн хэрэгслийн VRS бүртгэлийн санд байгаа тухайн компанийн өмчлөлд нийт 13 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэнээс дунд оврын автобус-1, том оврын 12 автобус бүртгэлтэй байна.

Улс хоорондын үйлчилгээнд Солонгос улсад үйлдвэрлэгдсэн том оврын автобус-6 ажиллах ба дундаж насжилт 9,6 жил.

Дүгнэх нь:

1. Тус компани тээврийн удирдлагын байртай, “НБЧ” ХХК болон “АйС ВН” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, дулаан зогсоолыг ашиглаж байгаа нь “Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага” MNS5831:2007 улсын стандартын 5.3 дахь /Автомашины засвар, оношлогоо-үйлчилгээний болон автомашиныг хадгалах дулаан байр, зогсоол, талбай бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ, тээврийн удирдлагын барилга байгууламжтай байна/ заалтыг хангасан;

2. Мэргэжлийн инженер, техникийн ажилтны орон тооны жишиг, нормативыг хангаж, ажил үүрэг, мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байгаа нь дээрх стандартын 5.7 дахь/Улс хоорондын автотээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтнаар хангагдсан байна. Инженер, техникийн ажилтан, жолооч нар нь ажил үүрэг, мэргэжлийнхээ чиглэлээр холбогдох мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна/, 11.2 дахь/Улс хоорондын автотээврийн аж ахуйн нэгж байгууллагын дарга нь зөвлөх инженерийн, алба хэлтсийн дарга, ерөнхий мэргэжилтнүүд нь мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдан, гэрчилгээ авсан байна/ заалтыг хангасан;

3. Нийт хөрөнгийн дүн 195'085'844'54 төг байгаа нь тус стандартын 7.1.1-д заасан “Тээвэрлэгч нь . . . тээвэрлэлтийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах санхүү, эдийн засгийн чадавхтай байна” гэсэн заалтыг хангасан;

4. Улс хоорондын үйлчилгээнд ажиллах автобус нь мөн стандартын 6.2.2-т заасан "1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар зориулагдсан суудал, гар тээшний тавиур, овор ихтэй тээш хадгалах зориулалтын хонгилтой байна" гэсэн заалтыг хангасан;

5. Тээвэрлэгч жолооч нар нь дээрх стандартын 10.2.1-д заасан "улс хоорондын зорчигч тээврийн автобусны жолооч нь 5-аас доошгүй жил, үүний дотор нийтийн тээврийн жолоочоор 3-аас доошгүй жил ажилласан байх", "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS5012:2011 улсын стандартын 8.2.1/ нийтийн тээврийн жолооч нь ерөнхий боловсролын суурь болон бүрэн дунд боловсролтой, автобусны жолооч бэлтгэх тусгай дамжаа дүүргэсэн, жолоочийн мэргэжлийн "Д" ангилалтай, тээвэрлэгч-жолоочоор мэргэшсэн 21-ээс дээш насны хүн байна/ дэх заалтыг бүрэн хангасан;

6. Цаашид өөрийн өмчийн үйлдвэр, үйлчилгээ/засвар, дулаан болон ил зогсоол/-ний барилга байгууламжтай болох шаардлагатай гэж дүгнэлээ.

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ



Э.ОЮУНТУНГАЛАГ